

ТАХЬКО (ХК) КОМПАНИЙН 2017 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН

НЭГ. КОМПАНИЙН ТУХАЙ

Тахько (ХК) компани Монгол улсын Засгийн газрын Өмч хувьчлалын комиссын 1992 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн 32 дугаар тогтоолоор хувьчлагдах шийдвэр гарч, Тахько хувьцаат компани (100 хувь хувийн өмчид шилжсэн) байгуулагдсан үеэс одоог хүртэл тасралтгүй үйл ажиллагаа явуулж байна.

Тус компани 1992 онд буюу хувьчлагдах үеийн эхлэлтийн балансаар 345,567.5 мянган төгрөгийн өөрийн хөрөнгөтэй, нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 592,830 ширхэг энгийн хувьцаатай байсан бол 2016 оны жилийн эцсийн байдлаар 14,863,401.8 мянган төгрөгийн хөрөнгөтэй, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй нэг бүр нь 168 төгрөгийн нэрлэсэн үнэтэй нийтэд зарласан чөлөөтэй арилжаалагдах 1,189,983 ширхэг энгийн хувьцаатай нээлттэй хувьцаат компани болно.

ХОЁР. 2017 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ

Компанийн засаглал

Тахько (ХК) компанийн захиргаа 2017 оны эхний хагас жилд (гүйцэтгэх удирдлага, зохион байгуулалтын нэгжийн албадууд) Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал, Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан шийдвэрийг хэрэгжүүлж, Компанийн дүрмийн хүрээнд үйл ажиллагаа явуулж ажилласан.

Компанийн захиргаа 2016 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, 2016 оны санхүүгийн тайланда аудит хийлгэсэн тухай PWC аудит компанийн дүгнэлт, Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлан хуралдуулах, аудитын компани сонгох, найдваргүй өр авлага, хөрөнгө оруулалтын тухай зэрэг асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, гарсан шийдвэрийг бүрэн хэрэгжүүлж ажилласан.

Компанийн захиргаа Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан шийдвэрийн дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуульд заасан хугацаа, төрийн зохицуулах байгууллагаас баталсан журамд заасан шаардлагад нийцүүлэн зарлаж, хүчин төгөлдөр саналын эрхийн 85.55 хувийн ирцтэйгээр хуралдуулж, хурлаар хэлэлцсэн Компанийн 2016 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоож, дотоод ажлын зардлын төсвийг батлах асуудлуудыг тус тус хуралд оролцогчдын 100 хувийн саналын эрхээр баталж шийдвэрлүүлсэн болно.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаас Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн 6, хараат бус 3 гишүүнийг сонгосон. Сонгогдсон гишүүд өмнө нь компанийн засаглалын сургалтад хамрагдсан, үүнээс хараат бус гишүүд нь Компанийн хуульд заасан шаардлага, шалгуурыг бүрэн хангаж байгаа болно.

Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр (ТУЗ-ийн 2017.02.09-ний №01 тогтоол)-ийн дагуу компанийн 2016 оны цэвэр ашгаас 1,189,983 ширхэг энгийн хувьцаанд хуваарилсан 128,518.2 мянган төгрөгийн ногдол ашгаас хувь хүний орлогын албан татварт 12,851.8 мянган төгрөг сүутган харьяалах татварын байгууллагад шилжүүлэн тайлагнаж, 115,666.3 мянган төгрөгийн ногдол ашгийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв компаниар зуучлуулан, бүртгэлийн өдрөөр ногдол ашиг хүртэх эрхтэй 623 хувьцаа эзэмшигчийн төвлөрсөн хадгаламж дахь дансанд 2017 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр байршуулан олгож, хууль, журам, гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид тогтоосон хугацаанд тайлагнаж, олон нийтэд болон хувьцаа эзэмшигчдэд мэдээлсэн болно.

Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 443 дугаар тогтоол, Монголын хөрөнгийн биржийн бүртгэлийн шинэ журам, Санхүүгийн зохицуулах хорооны 2017 оны 9/210 тоот албан даалгавар, Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн 2017 оны 01/52 тоот зөвлөмж, мэдээллийн хуанлийн дагуу санхүүгийн ба санхүүгийн бус тайлан, хугацаат ба тухай бүр мэдээлэх мэдээллийг хувьцаа эзэмшигч, олон нийт, зохих байгууллагуудад тогтоосон хугацаанд мэдээлж ажилласан.

Компанийн гүйцэтгэх удирдлагын ажилтнууд Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржээс зохион байгуулсан компанийн засаглалтай холбогдолтой хурал, семинар, сургалтад оролцож, судалгаа, мэлдээлэл авч компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд хэрэгжүүлэн ажиллаж байна.

Компанийн веб хуудасны мэдээ мэдээллийг тухай бүрт нь шинэчилж, Санхүүгийн зохицуулах хорооны журмын дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлын зар, хэлэлцэх асуудал, хурлаас гарах шийдвэрийн төсөл, Хувьцаа эзэмшигчдийн болон Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэр, компанийн бусад мэдээллийг мэдээлж, хувьцаа эзэмшигч болон олон нийтийг мэдээллээр хангах үүргийг хэрэгжүүлж байна.

Эхний хагас жилд их хэмжээний ба сонирхолын зөрчилтэй гэрээ хэлцэл хийгдээгүй, үнэт цаасны ханш, арилжааны хэмжээнд мэдэгдэхүйц нөлөөлөх нөхцөл байдал үүсч бий болоогүй болно.

Компани 2017 оны эхний хагас жилд Компанийн тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржийн тогтоол, шийдвэр, журмаар тогтоосон нээлттэй хувьцаат компанийн болон үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж, хэвшүүлж ажилласан болно.

Компанийн бүтэц, зохион байгуулалт

Компани 2017 оны эхний хагас жилд Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлага, Захиргааны болон Техник үйлчилгээний алба, Анкор төв гэсэн бүтэцтэй ажиллаж, байнгын ажлын байрны 28 ажиллагсадтай ажилласан.

Нийт ажилтнуудад Хөдөлмөрийн гэрээгээр тохиролцсон үндсэн цалинг олгож, Хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолтод заасан үүрэг, хариуцсан ажлын биелэлт, үр дүнг үндэслэн үндсэн цалингийн 40 хүртэл хувийн цалингийн урамшууллыг үргэлжлүүлэн олгож байна.

2017 оны эхний хагас жилд нийт ажилтнууд, удирдлага, ТУЗ-ийн гишүүдийн цалин, улирал, жилийн эцсийн шагнал, урамшуулалд нийтдээ 507,845.0 мянган төгрөг олгосон байна.

Компанийн 2016 оны санхүүгийн тайланг “А” форматаар болон санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (IFRS)-ын дагуу гаргаж, Прайсуотерхаускуперс аудит ХХК-аар олон улсын түвшингийн аудитын баталгаажуулалт хийлгэж, Төлөөлөн удирдах зөвлөл болон 2017 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэн батлуулсан.

2017 оны санхүүгийн тайланд аудит хийх компаниар Прайсуотерхаускуперс аудит ХХК-ийг дахин сонгох шийдвэр (Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017.06.09-ны 10 дугаар тогтоол) гаргуулж, Аудитын гэрээ байгуулахаар бэлтгэж байна.

Компанийн өмч хөрөнгө, ажилтныг эрсдэлээс хамгаалах зорилгоор Практикал даатгал компанитай үл хөдлөх хөрөнгө, тээврийн хэрэгсэл, тооног төхөөрөмж, жолоочийн хариуцлагын даатгалын гэрээнүүдийг шинээр байгуулж, гэрээнүүдийн дагуу 2017 оны эхний хагас жилд даатгалын хураамжинд 11,631.5 мянган төгрөг төлсөн байна.

Компанийн үндсэн үйл ажиллагааг хэвийн явуулах зорилгоор томоохон түрээслэгч (Мобиком корпораци ХХК, Ньюком пропрети ХХК, Скайтел ХХК)-тэй байгуулсан түрээсийн гэрээний хугацаа дуусах үед одоо хүчин төгөлдөр мөрдөж байгаа гэрээний ерөнхий нэхцэлөөр үргэлжлүүлэн байгуулах талаар түрээслэгч настай уулзалт зохион байгуулж, урьдчилан тохиролцож, зарим түрээслэгчтэй санамж бичиг үйлдэж албажуулсан.

Хүний нөөц, нийгмийн асуудал

Компани захиргаа тайлангийн хугацаанд 28 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж, тэдгээр ажилтнууд хууль тогтоомжид зааснаар давхардсан тоогоор 4333 өдөр ажиллахаас 3955 өдөр ажиллаж, 190 өдрийн ээлжийн амралтыг биеэр эдлүүлж, 4 ажилтан хөдөлмөрийн чадвар түр алдсан тул 123 өдрийн ажлаас чөлөөлөгдсөн байна.

Оффисын ажилтнуудын эрхэлсэн ажлын болон эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, боловсруулж байгаа асуудлын чанарыг сайжруулах, хууль эрх зүйн үндэслэл, албан хэрэг хөтлөлтийн стандартыг мөрдөхөд өдөр тутмын туслалцаа, зөвлөмжөөр хангаж, тэднийг хөгжүүлэхэд анхаарч ерөнхий мэдлэгийн түвшинг дээшлүүлэх зорилгоор компанийн ба нийгмийн даатгал, хувь хүний орлогын албан татварын хууль тогтоомж, эрүүл мэнд, эмийн зохистой хэрэглээний тухай болон компанийн дотоод ажил, хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилт, бусад асуудлаар сар тутамд 2 удаа сонсгол, мэдээлэл хийж байна.

Ажилтнуудын ажлын цаг ашиглалт, захиргааны чөлөө олголт, Хөдөлмөрийн дотоод журмаар хүлээсэн үүргийн биелэлт болон алба, ажилтнуудын ажлын тайланг бичүүлж, зохих түвшний хамт олны хурлаар сонсож, ажилтан бүрт дүгнэлт, зөвлөлгөө өгч, ажлын хариуцлага, хөдөлмөрийн сахилгыг бэхжүүлэхэд өдөр тутам хяналт тавьж, зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээ авч ажиллаж байна.

Ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах зорилгоор нийт ажилтнуудыг Улаанбаатар сонгдо эмнэлэгт компанийн зардлаар 5,200.0 мянган төгрөгийн үзлэг оношилгоонд хамрууллаа.

Компанийн хөдөлмөрийн дотоод журмын заалтыг үндэслэн эрүүл мэнд болон бусад шалтгаанаар гачигдал тохиолдсон тус компанийн 3 ажилтанд 6,744.4 мянган төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлсэн.

Оёдлын үйлдвэр, компанид ажиллаж байгаад тэтгэвэрт гарсан гачигдал тохиолдсон ахмад настан М.Урантулхүүрт 166.7 мянга, Н. Сээсэрт 333.3 мянган төгрөгийн буцалтгүй тусламж, харьяалах Нийгмийн даатгалын байгууллагад 300.0 мянган төгрөгийн хандив тус тус олгосон.

Хүрээлэн буй орчинг сайжруулах, хүчилтөрөгчийн эх үүсвэр нэмэгдүүлэх зорилгоор компанийн Гүнт амралтын хашаанд 115 ширхэг гацуур мод, өмнөх жилд тарьсан модыг арчилж, ургалтыг нэмэгдүүлэх ажлыг хийсэн.

ОРЛОГО НЭМЭГДҮҮЛЭХ, ХЭВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХАНГАХ

Компанийн орлого нэмэгдүүлэх, бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр

Компанийн бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор бүх төрлийн хог хаягдал, нүүрснээс шингэн түлш болон цахилгаан гаргаж авах төслийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг үргэлжлүүлэн хийж байна.

Төслийн бэлтгэл ажлын хүрээнд 2017 оны эхний хагас жилд Компанийн Хан-Уул дүүргийн гурвалжинд байрлах агуулахад өнгө үзэмж сайжруулах, талбайн тохижилтын ажлуудыг хийж, галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулж, байгаль орчны үнэлгээ хийлгэх ажлыг мэргэжлийн Эко Натур ХХК-иар гүйцэтгүүлж байна.

Дархан-Уул аймагт төслийн газрын тохижилт түүнтэй холбоотой асуудлаар 3 удаа томилолтоор ажиллаж холбогдох байгууллага, албан тушаалтнуудтай уулзалт зохион байгуулсан.

Төсөлд нийслэл, дүүрэг, орон нутгийн дэмжлэгийг авах ажлын хүрээнд эрх бүхий байгууллагын удирдлага, албан тушаалтнуудтай уулзалт хийж хамтран ажиллах санамж бичиг байгуулах зэрэг бэлтгэл ажлыг үргэлжлүүлэн явуулж байна.

Компанийн өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангах чиглэлээр

Компанийн барилгуудын дулааны хангамж, цэвэр бохир усны хэвийн ажиллагааг хангах зорилгоор МА-II барилгын 1-р давхрын агааржуулалтын системийг 15,777.4 мянган төгрөгийн өртгөөр, Гурвалжин дахь агуулахын өнгө үзэмж сайжруулах, талбайн тохижилтын ажлуудыг 13,306.8 мянган төгрөгийн өртгөөр, МА-I, МА-II, МА-III, U-I барилгуудын дулааны тоолуурт ээлжит засвар хийж, баталгаажуулах, , Гүнтийн байрны шугам хоолойг засварлах зэрэг 11,966.99 мянган төгрөгийн урсгал засварын ажил хийсэн байна.

Цахилгаан эрчим хүчний гадаад, дотоод тооцооны нийт 50 гаруй тоолуурын заалтаар цахилгаан эрчим хүчний хэрэглээний тооцоог тогтмол хийж, 154,784.2 мянган төгрөгийн цахилгаан эрчим хүчний үнийг хэрэглэгчдэд хувиарлан төлүүлсэн. Цахилгааны тоолуурын зөрүү 21,503.7, тарифийн зөрүү 6,191.8, үйлчилгээний үнэ

8,189.2 , дулааны төлбөрт 29,054.4 , үйлчилгээний төлбөрт 454,2 , цэвэр бохир усны төлбөрт 11,557.4 , усны үйлчилгээний төлбөрт 429.2, телефон ярианы төлбөрт 498.7 мянган төгрөгийг хэрэглэгчид хуваарилан төлүүлсэн байна.

Үндсэн хөрөнгийн өөрчлөлт, элэгдэл хорогдлын шимтгэл, сэлбэг, аж ахуй, барилга, хангамж, шатах тослох материал, кассын тооцоонд хяналт тавьж, анхан шатны баримтын бүрдүүлэлтийг бүрэн хийлгэж, тайлан бүртгэлийг зохих журмын дагуу хөтөлж ажилласанаар ямар нэгэн зөрчил дутагдал гараагүй, бэлэн мөнгөний зарцуулалт, түүнд тавих хяналт хэвшсэн болно.

Компанийн санхүүгийн тайлан тэнцэл, аж ахуйн нэгжийн орлогын, хувь хүний орлогын, үл хөдлөх эд хөрөнгийн, авто тээвэр өөрөө явах хэрэгслийн, нэмэгдсэн өртгийн албан татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан тооцоог тогтоосон хугацаанд нь гаргаж, хуульд заасан хугацаанд харилцдаг санхүү, татвар, нийгмийн даатгалын байгууллагад тушааж, тайлангийн хугацаанд улсын төсөвт 45,613.9 мянган төгрөгийн аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, 80,241.2 мянган төгрөг (үүнээс 55,186.8 нь компаниас, 25,054.4 нь даатгуулагчаас)-ийн нийгмийн даатгалын шимтгэл, 63,985.3 мянган төгрөг (ажиллагсдаас суутгасан 48,061.8 , ажил үүрэг гүйцэтгэгчээс суутгасан 3,071.7 , ногдол ашгаас суутгасан 12,851.8 мянган төгрөг)-ийн хувь хүний орлогын албан татвар, 10,854.7 мянган төгрөгийн үл хөдлөх хөрөнгө, газрын болон авто тээврийн болон өөрөө явагч тээврийн хэрэгслийн албан татвар, 120,045.5 мянган төгрөгийн нэмэгдсэн өртгийн албан татвар төлж, улсын төсөвт төлөх төлбөрийн 92.6 хувийг тайлангийн хугацаанд барагдуулсан байна.

Анкор төв үйл ажиллагааны чиглэлийн дагуу хурал, семинар, уулзалт 13 , хүлээн авалт 6 , шагнал гардуулах ёслол 3 , урлаг, соёлын тогтолт 4 , нийт 26 удаагийн, 106 цагийн арга хэмжээ, үйлчилгээ зохион байгуулж, (НӨАТ-гүй дүнгээр) 11,810.0 мянган төгрөгийн орлоготой ажилласан.

Компани 2017 оны эхний хагас жилд 1,776,422.5 мянган төгрөгийн орлоготой, 1,172,721.4 мянган төгрөгийн зарлагатай, 541,426.9 мянган төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажиллаж, 2016 оны эхний хагас жилийн гүйцэтгэлтэй харьцуулахад компанийн орлого 218,048.3 мянган төгрөг буюу 14.0 хувиар нэмэгдэж, зардал 198,806.4 мянган төгрөг буюу 14.5 хувиар буурч, хуримтлагдсан ашиг 3,581,935.9 мянган төгрөг болж 26.79 хувиар өссөн байна.

Ажлын байр, ажиллах нөхцөлийг хангах чиглэлээр

Ажиллагсдын ажлын нөхцөлийг хангах зорилгоор 2,950.0 мянган төгрөгийн үнэ бүхий компьютер, тэдгээрийн дагалдах хэрэгсэл, 211,200.0 мянган төгрөгийн суудлын ба бага оврын ачааны тээврийн хэрэгсэл худалдан авч бэлтгэсэн.

Албан ажлын хэрэгцээнд 7,750.0 мянган төгрөг (шатахуун 5,226.4, хангамжийн материал 2,523.6 мянган төгрөг)-ийн бараа материалыг бэлтгэн нийлүүлж хангалац хийсэн.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Л.ЭНХНАСАН

